



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар

01/04

Улаанбаатар хот

Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын  
газрын хөрөнгө данснаас дансанд  
шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хангамжийн материалын дансанд бүртгэлтэй 6,000,000.0 (зургаан сая) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500347

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны  
 №... Дугаар сарын...ны өдрийн дугаар тушаалын хавсралт



Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багахангай Дүүргийн Засаг даргын Тамгын газар

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр	
				Нэгж үнэ	Нийт үнэ			шилжүүлэх данс	бүртгэх данс
1	Гэр 6 ханатай гэр	ком	1	6,000,000.00	6,000,000.00	0.00	6,000,000.00	хангамж	Тавилга,эд хогшил
	Шилжүүлэх хөрөнгийн дүн						6,000,000.00		